

Сэдэв ба тайлбарт зургууд: Виллем де Винк

Аврагч Эзэн Есүс



Сэдэв ба тайлбарт зургууд: Виллем де Винк

Аврагч Эзэн Есүс




Монгол дахь анхны хэвлэл 1996. Нидерланд улсад хэвлэв.

© Зохиогчийн эрх бүхий байгууллага нь Stichting Wereldtaal, Houten, Нидерланд улс.
Зохиогчийн бүх эрх хүчин төгөлдөр.
Номыг бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

Монгол дахь түгээгч байгууллага нь:
Монголын Христийн Чуулган
Шуудангийн хайрцаг 109
Улаанбаатар 24
Монгол

Эх хувийг 1993 онд Нидерланд улсын хэвлэлийн газар хэвлэв.
Proclama, P.O. Box 91, 3958 ZV Amerongen, The Netherlands.



Ягаад ийм олон хүмүүс гол дээр цуглаа вэ?



Ертөнцийн Эзэний Хаант улс ойртож байна. Өөрсдийгөө бэлтгэцгээ!



Амьдралаа
шинээр эхэлцгээ!



Ертөнцийн Эзэний шийтгэлийн
сүх аль хэдийн модны үндсэн
дээр буулаа.



Сайн үр жимс өгдөггүй мод
болгон чавчигдаж галд
шатаагдах болно.




Бид бүгд чавчигдах байхдаа.
Тэгвэл бидний хэн нь тэр сайн
амьдралаар амьдрах юм бэ?



Тэр үнэн. Хэн ч Ертөнцийн Эзэний
шийтгэлээс зайлж чадахгүй.
Гэвч миний дараа ирэх нэгэн
хүн та нарын сэтгэл зүрхийг
өөрчилж чадна.



Хэрэв та нар гэмт амьдарлаа
өөрчлөхийг хүсч байвал хийсэн
гэм нүглээ гэмшицгээ, тэгээд
нааш ир би үүнийг чинь баталж
усаар угааж өгье.





Ингээд чи гэм нүглээ
ариутгаж амьдралаа
шинээр эхлэх боллоо.

Голын эрэг дээр сургаал зааж байсан тэр хүнийг хүн бүр Жоганбаптист хэмээн дууддаг байв.


Би бол чухал хүн биш.
Би Ертөнцийн Эзэн хэн болохыг та нарт таниулах тэр Хүний замыг бэлтгэгч юм.
Тэр та нарыг Ертөнцийн Эзэний Ариун Сүнсээр, Ертөнцийн Эзэний галаар батлан угаах болно. Энэ нь та нарыг жинхэнэ өөрчлөх болно.



Тэгээд дараа нь...



Та Өөрөө намайг угааж өгвөл зохистой!



Бид Их Эзэний хүслийг дагах ёстой. Намайг усаар угаа.




Аав аа, Таны Хаант улс ирж, энэ газар дээр Таны хүсэл биелэх болтугай!



Тэгээд тэнгэрээс дуун гарч ийнхүү хэлэв ...

Тийм ээ, Чи бол Миний Хүү. Чи бол Миний таалан соёрхдог хайртай Хүү минь билээ.



Манай эриний эхэн үед Жоганбаптис Израйльчуудыг Аврагч Эзэн ирэхэд бэлтгэж байлаа. Тэр үед Израйль нь агуу их Ромын хаант улсын нэгэн жижиг хэсэг нь байлаа.




Израйль улсын Иудей хүмүүс дарлагдан зовж байлаа. Тэд Аврагч Эзэн ирэх цагийг тэсч ядан хүлээнэ. Учир нь Иудейчуудын эртний номонд Түүний ирэхийг зөгнөн бичсэн байдаг. Тэр Аврагч Эзэн Ертөнцийн Эзэний шударга үнэнийг тогтоох болно.

Иордан голын эрэг дээр Жоганбаптис Есүсийг зааж.

Харцгаа! Энэ дэлхийн гэмийг зайлуулагч Ертөнцийн Эзэний Хурга нь энэ байна.



Усан баталгаа хийлгэсний дараа Ертөнцийн Эзэний Ариун Сүнс Есүсийг цөлд дагуулан авч иржээ.



Тэр цөлд 40 өдөр, шөнө байхдаа юу ч идэж уусангүй. Ийн байхдаа Өөрийнхөө үүргийг сайтар мэдэхийн тулд Ертөнцийн Эзэнээс мацаг барин залбиран гуйж байлаа.




Есүс Ертөнцийн Эзэний хүсэл зорилгыг дэлхийд харуулах хэрэгтэй байлаа. Энэ нь хүн төрөлхтнийг үхлийн савраас чөлөөлөх Ертөнцийн Эзэний төлөвлөгөө байв.

Есүс нүдэнд үл үзэгдэгч, үхэл зовлон, балар харанхуйг удирдагч Сатантай тэмцэх байв.



Аав аа! Би таны хүссэн бүхнийг хийх болно.




Гэвч Сатан Есүсийг уруу татаж, Түүнийг Ертөнцийн Эзэний зорилгыг биелүүлэхэд нь саад болохыг хичээж байлаа.

Хэрэв Чи Ертөнцийн Эзэний хүү мөн юм бол эдгээр чулууг талх болго! гэв.

Үгүй! Хүн зөвхөн хоолны хүчээр биш Ертөнцийн Эзэний үгээр амьд явдаг гэж Сургаалд бичигдсэн байдаг.




Хэрэв чи үнэхээр Ертөнцийн Эзэний Хүү мөн юм бол үүнийгээ баталж энэ сүмийн оройгоос үсэр. Ер бусын элч нар чамайг хамгаална гэж бичигдсэн байдаггүй билүү?




Ертөнцийн Эзэнийг хэзээ ч бүү сорь гэж бичигдсэн байдаг.

Хэрэв чи намайг хүндэтгэн, миний өмнө сөгдөн мөргөвөл би чамд энэ газар дээрх бүх эрх мэдэл, хүч чадлыг өгье.



Сатан чи эндээс тонил! Бид зөвхөн Ертөнцийн Эзэнд л үйлчилж Түүнийг хүндэтгэх ёстой гэж бичигдсэн байдаг.


Тэгэхэд Сатан Есүсийг орхин зайлав. Дараа нь Ер бусын элч нар Түүнд туслахаар ирэв.






Есүс Галил аймагт ирэхдээ Ариун Сүнсээр дүүрэн байлаа. Есүс энэхүү хүн ам шигүү суурьшсан, Израйлийн хойд хэсэгт орших нутагт өсөж торнисон юм. Түүнийг ийнхүү аялах явцад хэсэг хүмүүс Түүнтэй нэгдэв. Тэд Есүсийг зөнч нарын бичсэн Аврагч Эзэн мөн болов уу? хэмээн бодож байлаа.



Галил аймгийн Хана хотод нэгэн хурим болж байв...



Есүс ч бас энэ баярт ээж болон зарим найз нөхдийн хамт оролцож байлаа.







Хурим ид үргэлжилж байтал...

Одоо яанаа!
Дарс
дуусчихлаа!

Та нар Есүсийн
хэлсэн бүхнийг
гүйцэтгэ!



Энэ том савнуудыг усаар
дүүргээд найрын ахлагчид
амсуул гэв.



Ус аа? Үгүй ээ энэ чинь дарс
байна. Ямар сайхан дарс вэ?



Үүнийг амс даа!
Чи одоо болтол
хамгийн сайн
дарсыг нуусан
бололтой.



?



Би урьд өмнө ийм сайхан хурим хэзээ
ч үзсэнгүй. Ус дарс болчихлоо.
Тэгэхдээ хамгийн сайн дарс шүү!

Үүнийг Назар
хотын Есүс
хийсэн юм.

Тэр чинь
хэн бэ?

Хафарнаам бол Галил нуурын эрэг дээр оршдог загасчдын тосгон юм. Эндээс Есүс Ертөнцийн Эзэний Хаант улсын тухай хүмүүст ярьж эхэллээ.



Эндээс Есүс анхныхаа дагалдагчдыг сонгож авав.




Петр ээ! Завиа усны гүн тийш аваачъя. Тэгээд тороо тэнд хая.





Эзэнтээн! Бид шөнжингөө ажилласан боловч нэг ч загас барьсангүй.




Гэвч Та тэг гэж байгаа бол...



Хараач!
Ямар итгэмээргүй юм бэ!




Есүс дагалдагч нартайгаа
Галил аймгаар хэрэн явж,
Ертөнцийн Эзэний Хаант улсын
тухай хүн бүхэнд ярьж байлаа.
Тэрээр янз бүрийн өвчтэй
хүмүүсийг эдгээж,
муу ёрын сүнсийг хүмүүсээс
зайлуулахад олон хүмүүс гайхан
биширч Түүнийг дагадаг байлаа.
Түүгээр ч үл барам бусад аймгууд,
Израйлийн нийслэл Иерусалим
хотоос ч хүмүүс ирж,
Түүний хэлсэн үг бүрийг
дуулгавартай сонсож байлаа.




Ядуу дорой хүмүүс жаргалтай. Ертөнцийн
Эзэний Хаант улс тэднийх юм.


Өлсгөлөн хүмүүс жаргалтай.
Учир нь тэд хангалуун болно.




Үйлж буй хүмүүс жаргалтай.
Учир нь тэд баяр
баясгалантай болно.




Надаас болж бусдад хавчигдсан
хүн баяр жаргалтай. Учир нь Ер
бусын улсад очоод тэдний
хүртэх шагнал нь асар их юм.




Бусдаас сайн сайхныг хүсдэг бол өөрсдөө тэдэнд сайн юм хийж өг.




Дайсандаа хайртай байж, тэдний төлөө Их Эзэнээс гуйж бай.



Бусдын анхаарлыг татахгүйн тулд сайн үйлийг нууцаар үйлд.




Эмэгтэй хүнийг хараад сэтгэлдээ тачаадсан эр хүн сэтгэлдээ завхайрсан хэрэг.



Хүний нүд хорвоог харах гэрэл болдог. Нүд сохорвол хорвоо ертөнцийг харж чадахгүйн адил таны санаа сэтгэл гэмтэй бол амьдрал тань харанхуй мэт болно.



Хүн хоёр эзэнд зэрэг үйлчилж чадахгүйн адил Ертөнцийн Эзэн болон эд баялагт зэрэг дээр үйлчилж чадахгүй.



Маргаашийн тухай бүү санаа зов. Юуны түрүүнд Ертөнцийн Эзэний Хаант улсын үнэнийг хай. Ингэж чадвал бусад бүх зүйлс бүтэмжтэй байх болно.




Миний үгийг сонсоод Намайг дагасан хүн чулуун суурьтай байшингийн эзэн мэт. Харин Миний үгийг дагаагүй хүн элсэн барьсан суурьгүй байшингийн эзэн мэт.



Нэгэн өдөр Хафарнаам дахь Есүсийн байсан байшингийн гадна олон хүмүүс цугларсан байлаа.

Бид цугларсан олныг нэвтэрч орж чадахгүй нь бололтой.




Байшингийн дээвэр дээр гараад дамнуургатай нь доош буулгая.

Дээр юу болоод байна вэ?



Тэднийг бүү хоригло! Түүний найзууд нь их итгэлтэй хүмүүс юм.



Чиний гэмийг цагаатгалаа.

Та нар сонсов уу? Тэр яаж ингэж хэлж болно вэ?



Тэр Ертөнцийн Эзэнийг доромжилж байна.


Зөвхөн Ертөнцийн Эзэн нь л хүний гэмийг уучилж чадна.

Тахир татуу хүнд: “Чиний гэмийг уучиллаа” эсвэл “Чи бос” гэж хэлэхийн аль нь амархан бэ?



Аврагч Эзэн хүний гэмийг уучлах эрхтэй. Мөн “Бос дамнуургаа аваад яв” гэж хэлэх ч эрхтэй.





Үнэмшмээргүй юм!


Хараач! Тэр явж чаддаг болжээ.

Ура! Би явж чаддаг боллоо!


Гэвч хүн бүр Есүсийн үйл ажилд дуртай байсангүй. Шашны удирдагчид Түүнийг Бямба гаригийн амралтын өдрийн дүрмийг биелүүлж байна уу гэдгийг үргэлж ажиглаж байлаа. Энэ өдөр Израйль даяар ямар нэгэн ажил хийхийг хатуу хориглодог байжээ.



Энэ бол хатинги гартай хүн. Энэ өдөр сайн үйлс хийж болох уу?



Гараа сунга!





Хүмүүсээ! Би эдгэрчихлээ.



Бид Түүнийг эндээс зайлуулах хэрэгтэй!

Иерусалимийн удирдагчдад, Тэр ард түмнийг буруу зам руу хөтөлж байна гэдгийг хэлэх хэрэгтэй!

Есүс дагалдагчдынхаа хамт Галил нуурыг гаталж явлаа.





Эзэн минь ээ!
Туслаарай!
Бид живж байна.



Та нар юунд айгаав?
Та нарын итгэл
чинь хаачаав?



Аядагтун!



Тэд завиа уулын хажуугийн хадан
цохионд газардууллаа...



Аа-аа-аа!




Ууланд амьдардаг, адгийн муу ёрын сүнсэнд эзлэгдсэн нэгэн хүн байв...



Тэр ирж байна!

Түүнийг дээ нэг...!



Өө, Есүс үү!



Бузар муу ёрын сүнс чи түүнийг орхи.

Аугаа Их Эзэний Хүү би танд ямар хамаатай юм бэ?







Чиний нэр хэн бэ?

Намайг Түмэн гэдэг, ягаад гэвэл бид олуулаа учраас.



Биднийг гахайнд оруулаач!

Яь!






Би та нарт хэлж байна: Ертөнцийн Эзэний Хүү ганцаараа юу ч хийж чадахгүй. Тэр зөвхөн Өөрийн Эцгийн юу хийдгийг харснаа хийдэг. Би өөрийн хүслийг биш, харин Эцгийнхээ хүслийг дагадаг. Тэр бол Намайг илгээгч мөн.




Есүс чимээгүй газар тогтмол очиж Ертөнцийн Эзэнтэй ярьдаг байв.




Шөнөжин Ертөнцийн Эзэнтэй ярьсны эцэст Есүс 12 дагалдагчаа сонгон авав. Тэр дагалдагчдаа хоёр хоёроор нь илгээхдээ тэдэнд элдэв өвчин эдгээх, адгийн муу ёрын сүнснүүдийг зайлуулах хүч чадал өгчээ.



Ах дүү Петр Андрей хоёр...




Ах дүү Яахоб Иоган хоёр...




Филипп Бартоломай хоёр...


Томас, Матай хоёр (тэд урьд нь Ромын эзлэн түрэмгийлэгчдийн албан татвар хураагчид байв)...



Тадай, Альфаны Яахоб хоёр...



Зелэт намын гишүүн Симон, Хариот хотын Иудас хоёр.



Ингээд яв! Та нарыг хүлээн авсан хэн боловч Намайг хүлээн авсантай адил. Намайг хүлээн авсан хэн боловч Намайг илгээгч Ертөнцийн Эзэнийг хүлээн авсан хэрэг.



Арван хоёр дагалдагчид хийсэн ажилдаа цэтгэл хангалуун, баяр хөөртэйгээр буцаж ирлээ. Есүс тэдэнтэй хүнгүй газар хамтдаа байхыг хүссэн боловч цугларсан олон тийм боломжийг өгсөнгүй.

Ургац арвин ургасан боловч ажиллах хүч бага байна. Иймд ургацын Их Эзэнээс ургац хураахад ажиллах олон хүмүүсийг илгээж өгнө үү гэж гуйцгаа!




Есүс дахин сургаалаа зааж, хүмүүсийг эдгээж эхэллээ. Орой болж байлаа...

Филип ээ, энэ олон хүмүүс хаанаас хоол олох вэ? Та нар тэдэнд идэх юм өгвөл ямар вэ?




Найман сарын ажлын хөлс ч хүрэхгүй.


Энэ хүүд таван талх хоёр загас л байна. Энд үүнээс өөр идэх зүйл алга.




Хүмүүсийг 50, 50 иар нь хэсэг болгон суулга.




Есүс Ертөнцийн Эзэнд талархаад...



Тэрээр талх загасаа хуваав.





Есүс хоол тараан
өгөхөд олон мянган
хүмүүс цадтал
хооллолоо...



Тэр ирэх ёстой Аврагч
Эзэн мөн байна.


Бид Түүнийг Хаанд
өргөмжлөх хэрэгтэй!



Хараач! Хоолны
үлдэгдэл 12
сагс дүүрч
байна.



Одоо хүмүүс гэр гэртээ харих цаг болжээ.
Та нар завиараа нуурын цаад эрэгт хүрч оч.
Би энэ ууланд үлдээд Ертөнцийн Эзэнтэй ярина.



Үдэш нь...




Хүүш!
Чөтгөр байна.

Бүү ай!
Би байна.



Эзэн минь ээ, хэрэв Та
мөн бол намайг ч бас
усан дээгүүр явуулж
Тань дээр очуулаач.

Петр ээ,
Нааш
ир!



Эзэн минь,
намайг
авраарай!



Петр ээ, чи юунд
эргэлзсэн
юм бэ?

Хүмүүс Есүсийг Хаан болгон өргөмжлөхийг хүсэж байлаа. Тэд нар Түүнийг удирдагч болговол Ромын эзэнт улсын дарлалаас чөлөөлөгдөнө гэж найдаж байв. Гэвч Есүсийг эсэргүүцэгчид ч бас олон болж байлаа.

Тэд Түүнийг үргэлж шүүмжлэн мүүчилдаг байв.

Тэд хүмүүсийг Есүсийн эсрэг хандуулж, Түүнийг зайлуулахыг хүсэж байлаа.



Эзэнтээн, Та хэзээ хүрээд ирсэн юм бэ?

Та нар намайг хоол өгсөн учраас хайгаа юу?

Ялзарч мууддаг хоолны төлөө бүү санаа тавь. Харин мөнхийн амийг өгөгч хоолны төлөө амьдар.



Би бол мөнхийн амийг өгөгч талх. Би энэ дэлхийн төлөө биеэ өгнө.



Энэ хүн бидэнд яаж өөрийн биеийг өгч идүүлэх юм бэ?

Тэнэг юм!



За больцгоо, эндээс явцгаая!



Энэ хүн хүмүүсийг хууран мэхэлж байна.



Та нар бас энэ хүмүүсийн нэгэн адил явахыг хүсэж байна уу?

Их Эзэн минь, Таны үг бол мөнхийн амийг өгөгч билээ. Бид Таниас өөр хэнийг дагах билээ!





Иерусалим хотын гадна талд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг Ромын шийтгэлээр шийтгэн цовдолж алдаг нэгэн газар байлаа.



Минийх байхыг хүссэн хэн боловч өөрийгөө хойш тавин Намайг дагах ёстой.



Өөрийнхөө амьдралаас салж чадахгүй зууралдсан хэн боловч эцэст нь түүнийгээ алдана. Харин Миний төлөө бүгдийг алдсан хүн хүссэн зүйлээ олох болно.



Цорын ганц Ертөнцийн Эзэн байдаг гэдгийг чи сайтар ойлгох хэрэгтэй.



Бүх сэтгэл зүрхээрээ Ертөнцийн Эзэнд хайртай байж, мөн бусдыг өөрийн адил хайрлах нь хамгийн чухал!




Тэр үед Израйль улсад хулгана яртай хүмүүс амьдардаг тосгон байлаа. Хулгана яр өвчин нь арьсны бузар муухай өвчин юм. Ийм өвчтэй хүмүүсийг эрүүл хүмүүсийн дунд байхыг хориглодог байжээ.





Хулгана яртай хүмүүс явсан газар болгондоо хүмүүст ирж яваагаа мэдэгдэхийн тулд ингэж хашгирдаг байв.

Хулгана яртнууд!
Хулгана яртнууд!



Есүс! Эзэн минь!
Биднийг өрөвдөөч дээ.






Явцгаа. Одоо сүмийн зэрэгтэнд очиж биеэ үзүүл!




Сүмийн зэрэгтэнд очих ий? Биеэ үзүүлэх гэж үү?

Тэгээд бид эдгэрэх бол уу?



?

!




Хараач! Би эдгэрчихлээ!



Бид эрүүл болчихлоо!

Тийм байна!



Халлелүүяа! Ертөнцийн Эзэн сайн Эзэн! Баярлалаа!



Та нар 10 уулаа байсан биш билүү? Бусад нь хаана байна. Тэд ирж Ертөнцийн Эзэнд талархлаа илэрхийлэхгүй гэж үү?




Бос! Итгэл чинь чамайг эдгээгээд зогссонгүй бас аварлаа.

Иерусалим хотын
Еврейчүүдийн удирдагчид
Есүсийн хийж байгаа
бүгдийг тагнан туршихын
тулд өөрсдийн хүмүүсийг
явуулсан байв. Тэд нар
Есүсийн хийж буй
бүхий л зүйлийг
эсэргүүцэж байлаа.

Тэр хамгийн муу хүмүүс гэж
үзэгддэг байсан завхай хүүхнүүд,
Ромын татвар хураагчид гэх мэт
хүмүүстэй уулзаж байлаа.

Аврагч Эзэн хаягдсан
хүмүүсийг эрж хайж
тэднийг аврахаар ирсэн.





Учир нь Есүс Бямба гаригийн
амралтын өдөр хүн
эдгээжээ...

Эдгэр!

Тэр бас хүүхдүүдэд онцгой
анхаарал тавьж байлаа...


Хүүхдүүдийг Над дээр
чөлөөтэй авчир. Ертөнцийн
Эзэний Хаант улс эдэн шиг
хүмүүсийнх юм.




Иерусалим хотоос холгүй орших Бэтан хотоос Есүсийг дуудууллаа. Учир нь Лазар өвчилсөн байжээ. Лазар болон түүний эмэгтэй дүү Март, Марь нар Есүсийн дотны найзууд байлаа. Ингээд Есүсийг Бэтэнд ирэхэд Лазарыг оршуулаад дөрөв хоносон гэдгийг Тэр хүмүүсээс сонслоо.




Их Эзэн! Та энд байсан бол миний ах үхэхгүй байсан юм!



Март аа, чиний ах дахин амилах болно.



Тиймээ, би мэднэ. Энэ дэлхийн эцсийн өдөр ирэхэд Ертөнцийн Эзэн бүх нас барсан хүнийг амилуулахдаа түүнийг бас амилуулна.



Би бол дахин амилуулагч ба амийг өгөгч. Надад итгэсэн хэн боловч мөнхийн амьтай болно. Март аа чи үүнд итгэж байна уу?



Итгэж байна. Та бол энэ дэлхийд илгээгдэхээр амлагдсан Аврагч Эзэн, Ертөнцийн Эзэний Хүү мөн.




Та нар түүнийг хаана оршуулсан бэ?

Их Эзэн, очиж үзнэ үү.





Иерусалим хотын эрх баригчид Есүс болон дагалдагчдын талаар улам бүр анхаарах болов.




Тэр Хүн олон гайхамшиг үзүүлж байна.

Хэрэв бид үүнийг зогсоохгүй бол Ромчууд бидний эсрэг хөдөлнө!

Тэгэхдээ Ромчууд манай сүм, улс үндэстэнг устгах болно доо!



Та нар бодоод үз л дээ! Улс үндэстэн устгагдан сөнөөгдснөөс ганц хүн тер бүгдийн өмнөөс үхсэн нь дээр биш үү.




Иймээс Есүсийг алах нь зүйтэй!


Энэ мөчөөс эхлэн Еврейчүүдийн ахлагч нар Есүсийг Ромчуудад барьж өгөх боломжийг хайж эхлэв. Зөвхөн тэд л үхлийн ял оноож чадах эрх мэдэлтэй байв.



Есүсийг Бэтэнд байхад...



Марь!



Энэ чинь нард гэдэг
анхилуун тос уу?
Маш их үнэтэй эд шүү!




Ингэхийн
оронд мөнгийг
нь ядууст
өгсөн бол
дээр байсан
юм!




Иудас аа! Түүний хэрэгт бүү
оролц! Марь Миний биеийг
оршуулахад бэлтгэлээ.



Удахгүй Дээгүүр өнгөрөх гэдэг баяр болно.
Энэ баярыг тэмдэглэхээр олон хүмүүс
Иерусалим хотод ирж байлаа.




Иерусалим хотод Еврейчүүдийн
ахлагчид Есүсийг баривчлах
төлөвлөгөө зохиож байлаа.
Гэсэн ч Тэр хотод ирлээ.



Хүмүүс Түүнийг ирсэнд баярлан, хурай хашгиран угтан авцгаав.



Мандтугай!

Мандтугай!



Ертөнцийн Эзэнийг төлөөлөн ирсэн Хүн мандтугай!


Израйлийн Хаан мандтугай!




Бүх дэлхий Түүнийг дагаж байх шив дээ.

Бид юу ч хийж чадахгүй нь дээ.

Нийслэл хотод орших сүм нь
Ертөнцийн Эзэнийг магтан
хүндэтгэх төв байна.



Дээгүүр өнгөрөх баярын үеэр
хурга нядалдаг байв.



Хүмүүс Ертөнцийн Эзэнтэй
эвлэрэхийн тулд сүмд хурга
өргөдөг байлаа.




Гэвч ямар хурган барьц
хүмүүсийг гэм нүглээс нь
бүрэн чөлөөж чадах вэ?







Сүмийн хашаанд хүмүүс худалдаа хийж, мөнгө
солин завгүй байлаа.




Есүс бас тэнд ирлээ...






Ертөнцийн Эзэний сүм бол Түүнийг хүндэтгэх газар байх ёстой. Харин та нар үүнийг дээрэмчдийн үүрлэх хонгил мэт болгожээ!



Тэр маш аюултай хүн. Хүмүүс Түүний хэлсэн үг бүрт итгэж байна.



Бид Түүнийг түргэн устгах ёстой!




Хэрэв бид заль хэрэглэвэл Түүнийг барьж чадна. Тэгээд Түүнийг алуулъя.

Гэвч энэ баярын үеэр болохгүй. Дээгүүр өнгөрөх баярын үеэр ийм юм хийх нь осолтой.

Түүнийг барьж өгвөл та нар надад хэдийг төлөх вэ?


Энэ Түүний дагалдагчдын нэг Иудас байна!




Би та нарт Есүсийг барьж өгнөө.



Есүсийг барьж өгсний чинь төлөө бид чамд нэг боолын үнэтэй тэнцэх 30 мөнгөн зоос өгье.




Хэдийгээр удирдагчид Есүст төвөг учруулахыг хичээж байсан боловч Тэр Дээгүүр өнгөрөх баярын урьд өдрүүдийг сүмд хүмүүст сургаал зааж өнгөрүүлэв.




Тэр үдэш Есүс болон Түүний 12 дагалдагчид Дээгүүр өнгөрөх баярын зоог барихаар хотод цугларцгаав.







Би тамлагдан зовохоосоо өмнө та нартай хамт энэхүү Дээгүүр өнгөрөх баярын зоогийг барихыг хүсэж байсан юм.




Эрх тушаалтай хүмүүс бусдыг өөртөө үйлчлүүлдэг. Харин та нар тэднээс өөр байх хэрэгтэй.





Бүгдийн зарц болж чадах хүн нь та нарын удирдагч байх ёстой.



Би та нарын зарц мэт билээ.







Үүнийг ямагт хийн Намайг дурсаж яваарай...



Үүнийг ид!
Энэ талх Миний биетэй адил.



Үүнийг уугтун! Энэ бол та нарын төлөө урсгах Миний цусыг төлөөлнө. Ийнхүү Ертөнцийн Эзэн та нартай шинэ гэрээ тогтоож байна.



Би та нарт нэгэн шинэ тушаал өгье. Би та нарыг хайралдагтай адил та нар бие биенээ хайрла.



Хэрэв энэ хайр та нарын дунд байвал бүх хүн та нарыг Миний дагалдагч болохыг мэдэх болно.



Их Эзээн! Би Таны замаас хэзээ ч ухрахгүй. Би бүх амьдралаа Танд зориулна.



Петр ээ, азраган тахиа донгодохоос өмнө чи надаас гурван удаа урвана.

Тэр орой Есүс дагалдагчдынхаа хамт хотоос гарав. Иудас тэдний дунд байсангүй...

Би та нарыг орхин одох болно. Гэвч Аав минь та нарт Ариун Сүнсээ илгээх болно. Тэр та нарт тусалж, үргэлж хамт байх болно.

Та нар миний очих газарт хүрэх замыг мэднэ.


Би бол үнэн ба амьдралд хүрэх зам. Хэн ч Надаар дамжихгүйгээр Ертөнцийн Эзэн Эцэг дээр минь очиж чадахгүй.

Та нар эндээ байж бай. Би жаахан холдож Ертөнцийн Эзэнтэй ярья.


Аав аа, хэрэв боломжтой бол энэ зовлонг Надаас зайлуулж өгөөч.

Гэвч Та миний хүслийг биш Өөрийнхөө хүслийг биелүүл.

Та нар ийм үед яаж ингэж унтаж болно вэ? Босцгоо! Одоо Намайг барьж өгөх урвагч энд ирж байна.



Миний үнссэн хүнийг бариарай.



Эзэнтээн! Та амар байна уу?




Иудас, чи Аврагч Их Эзэнийг үнсэлтээрээ тэдэнд барьж өгөх гэж байна уу?

Их Эзээн, бид тулалдах уу?



Үгүй!
Хэрэггүй!



Есүс тэдэнд Өөрийг нь барьж авч явахыг зөвшөөрөв. Дагалдагчид нь тал бүр тийш зугтан одов.



Есүсийг бүх Еврейчүүдийн ахлагч сүмийн тэргүүнийх рүү аваачив. Петр, Иоган хоёр холоос дагаж байв.



Петр сүмийн хашаан дотор орж ирэв.




Чи Есүстэй хамт байсан билүү?



Үгүй! Би тэр хүнийг танихгүй!

Чи тед нарын нэг байхаа?



Биш ээ!




Би сайн мэдэж байна. Чи тэдэнтэй хамт байсан. Чи Галилийн хүн мөн байна.

Би та нарын юу яриад байгааг чинь ойлгохгүй байна.






Го-гоо-
го-го.



Чи Ертөнцийн
Эзэний Хүү
юм уу?



Чи бүгдийг мэддэг гэлүү,
тэгвэл хэн чамайг цохиж
байгааг хэл л дээ.



Өглөө нь Есүсийг Еврейчүүдийн ахлагч нарын
зөвлөлийн хуралдаан дээр авчрав.


Чи Ертөнцийн
Эзэний Хүү
юм уу?

Таны хэлснээр
чинь юм.




Худалч! Чи үхвэл таарна.
Ромчуудаар Түүнийг
тамлуулан алуул.

Есүсийг Ромын хаант улсын Понти-Пилат захирагчийнд авчрав. Еврейчүүдийн ахлагч нар хурсан олныг турхирсан тул Түүнийг янз бүрээр буруутган хашгиралдаж байлаа.




Та тэдний мэдүүлгийг сонслоо. Хэлэх юм байна уу? Юу ч байхгүй юу?




Чи юу хийсэн юм бэ?


Би үнэнийг гэрчлэхээр ирсэн юм.






Тэр үнэн гэдэг чинь юу юм бэ?





Энэ хүн ямар ч гэм хийгээгүй юм байна. Дээгүүр өнгөрөх баярын үеэр нэг хоригдлыг чөлөөлдөг. Хэнийг чөлөөлөх вэ? Барабыг уу, эсвэл Еврейн Хааныг уу?











“Еврейн Хаан Есүс” гэсэн бичгийг гурван хэл дээр бичиж модон загалмай дээр хадсан байв.

Есүс өвчин намдаахаар өгсөн дарснаац уухыг татгалзав.

Цэргүүд Түүний хувцсаар мөрийцөн наадав.



Бусдыг аварсныхаа адил одоо өөрийгөө авраач?

Хэрэв чи Ертөнцийн Эзэний Хүү юм бол наад загалмайнаасаа буугаад ир!

Та Өөрийгөө, бас биднийг авраач!


Ертөнцийн Эзэнийг бага боловч хүндлээч. Бид хоёр авах ёстой шийтгэлээ авсан, харин энэ Хүн бол ямар ч муу юм хийгээгүй.

Та Өөрийн Хаант Улсдаа орохдоо намайг бодоорой!

Өнөөдөр чи Миний хамт диваажинд орохыг Би амлаж байна.



12 цагийн орчим нар хиртэж,
газар сайгүй харанхуй болов.



Есүсийн эх Марь, түүний дагалдагч
Иоган нар модон загалмайн
ойролцоо зогсож байлаа.

Одоо та хоёр ээж,
хүү боллоо.



Ертөнцийн Эзэн минь,
Ертөнцийн Эзэн минь,
Та юунд Намайг орхино вэ?


Би... цангаж
байна!



Аав аа,
Сүнсээ Таны гарт өгье!



Гүйцлээ.



Есүс үд дунд гурван цагийн үед нас барав.
Нэг цэрэг хавирга руу нь жадаар сүлбэхэд ус,
цус садран урслаа.



“Түүнийг хурга мэт нядлана”
гэж сургаалд байдаг байх аа?



“Тэр бидний гэмийн төлөөс
болж жадлуулан тамлагдана”
гэж байдаг. Харин тэр
одоо нэгэнт нас баржээ.



Тэр ирэх ёстой гэж зөгнөгдөж
байсан Аврагч Эзэн мөн
болов уу? Биш болов уу?



Явцгаая, Түүний шарилыг авч,
оршуулж болох уу гэж
гуйцгаая.




Аримат хотын Иосиф, Ниходем нар Есүсийн
биеийг загалмайгаас авч, сайхан үнэртэй тос
түрхээд, маалинган нэхмэлд ороож, үхэр
чулуугаар тагласан хадан агуйд оршуулав.




Дээгүүр өнгөрөх баярын үеэр сүүлийн амралтын өдрийг өнгөрөөгөөд, хэсэг хүүхнүүд чулуугаар тагласан булш руу гашуудацгаахаар очжээ.




Агуйн амны үхэр чулууг зайлуулчихаж.



Та нар үхдлийн булшин дотор амьд хүнийг юунд эрээв? Тэр дахин амь орсон! Явж, Түүний дагалдагчдад хэл хүргэ!




Петр, Иоган хоёр үүнийг сонсонгуут агуйд гүйж ирэв.



Юу болсох нь энэ вэ?



Хов хоосон байна!



Агуйн гадна орших цэцэрлэгт...

Эмэгтэй, юунд уйлаав?
Хэнийг эрж байгаа юм?

Эрхэм ээ! Та Түүний
шарилыг авсан уу?


Марь!

Багш минь!

Ах дүүс нарт маань
очиж, Намайг миний
Эцэг, та нарын Эцэг,
миний Эзэн та нарын
Эзэн рүүгээ буцах гэж
байна гэж хэл.


Тэр өдөр Есүсийг дагадаг байсан 2 хүн ихэд сэтгэлээр унаад явж байтал, замд нь тааралдсан нэгэн хүн Есүсийг цаазалсан тухай яриа үүсгэв.

Та нар зарлагуудын зөгнөлд итгэдэггүй гэж үү? Аврагч Эзэн Өөрийн сүр жавхлантай байдалд оройн тулд зовлон эдлэх учиртай биш үү? Энэ бүгдийг Сургаалд бичсэн байдаг шүү дээ?



Хоолны үеэр гэнэт өнөөх хүн алга болов...

Тэр Есүс мөн байсан!



Тэд даруй Есүсийн бусад дагалдагчдыг олохоор явлаа.


Бид Их Эзэнийг харлаа!

Марь, Петр хоёр бас харсан байна!



Гэнэт...

Амар амгаланг хүсье!



Та нар Намайг гэдэгт итгэхгүй байна уу? Миний гар хөлийг харцгаа!





Их Эзэн минь! Ертөнцийн Эзэн минь!



Есүс дахин амилснаасаа хойш 40 хоногийн турш дагалдагчиддаа үзэгдэж байлаа. Нэгэн удаа бур 500 хүнд зэрэг үзэгджээ.

Нэгэн удаа Түүний дагалдагчид Галил Нууранд загасчилж байлаа...



Пэтр ээ, чи надад
үнэхээр хайртай юу?



Есүс Пэтрээс энэ асуултаа
гурав дахин асуулаа...



Тиймээ, би Танд хайртай
гэдгийг Та мэднэ.



Миний хонин сүргийг хариул!

Намайг
дага!



Би тэнгэр газрыг захирах бүх эрх
мэдлийг авсан. Та нар тал бүр тийш
яваад, дэлхийн бүх улс үндэстнийг
Надад итгүүлж, Миний хойноос дагуул.
Тэгээд Ертөнцийн Эзэн Эцэг, Хүү,
Ариун Сүнсний нэр дээр тэднийг
усаар угаа. Миний та нарт зааж
өгсөн бүгдийг тэдэнд зааж өг.


Энэ дэлхийд эцсийн өдөр ирэх хүртэл Би
та нартай өдөр бүр хамт байх болно
гэдгийг үргэлж санаж яв.



Ингэж хэлээд Есүс газар
дэлхийг орхиж, Ертөнцийн
Эзэний мөнхийн
улсад очлоо.
Гэвч Тэр эргэн ирж хүн
төрөлхтнийг шүүх болно
гэдгээ бас хэлсэн юм...


Есүс газар дэлхийг орхин одов.
Дагалдагчид нь Иерусалим хотод Ертөнцийн Эзэний Ариун Сүнсийг авахыг хүсэн, Түүнээс гуйж байлаа. Есүст байсан тэр Сүнс одоо тэдний дотор амьдрах болжээ.
Ариун Сүнс тэд нарыг Есүсийн тухай хүчтэйгээр гэрчлэгч шинэ хүмүүс болгон өөрчилжээ.

Үхэл Түүнийг дийлж чадсангүй. Ертөнцийн Эзэн Түүнийг дахин амилуулж, Аврагч Их Эзэн болголоо.



Есүсийн дагалдагчид асар их эсэргүүцэлтэй тулгарсан ч газар сайгүй очив.

Есүс бол Ертөнцийн Эзэний Хүү.





Энэ мэдээг бас захиагаар тунхаглалаа.

Тэр загалмайд цовдлогдож алагдахдаа бидний гэм нүглийг Өөртөө авсан юм. Тийм ч учраас бид одооноос гэмээсээ үхсэн мэт ангижирч, Ертөнцийн Эзэний хүссэнээр амьдарч чадах боллоо.

Одоо дэлхийн өнцөг булан бүрт Есүст итгэгчид хамтдаа цуглан уулзаж, Ертөнцийн Эзэнтэй ярьж, Библи уншдаг. Тэд талх хувааж, дарс дамжуулан амсаж, Есүсийн үхлийг санаж дурсдаг. Итгэгчид сэтгэл зүрхэндээ орших Есүсийн хайрыг өөр хоорондоо болон бусадтай хуваалцаж байхыг Ертөнцийн Эзэн хүсч байдаг.

Есүс Ертөнцийн Эзэний
хүн төрөлхтөнд зориулсан
төлөвлөгөөг боломжтой
болгосон юм.



Есүс бидэнд хайртай!
Түүнд талархаж, магтан
хүндэтгэж бай!



Ертөнцийн Эзэн дэлхийг
хайрлан цорын ганц
Хүүгээ өгсөн.
Түүнд итгэгч хүн бүр
мөхөхгүй, харин мөнх
амийг авна.

Есүсийн тухай илүү мэдье гэвэл:

Есүсийн амьдарч байсан тухайн үеийн дөрвөн хүн Түүний тухай ном бичиж, гэрчлэл хийж үлдээжээ. Эдгээр номыг Библид багтааж, “Сайхан мэдээ” гэж нэрлэсэн байдаг.

Матай

Матай бол Есүсийн 12 дагалдагчдын нэг юм. Тэрээр Хафернаам хотод албан татвар хураагч хийж байх үедээ Есүстэй нийлжээ. Хүмүүс Есүсийг татвар хураагчтай нийлсэнд гайхацгааж байв. Матай Есүсийн тухай маш олон гэрчлэл, түүх бичиж үлдээсэн юм.

Маарх

Маарх Авралын зарын (Авралын зар гэдэг нь Сайхан мэдээ гэсэн утгатай) жижиг ном бичсэн. Тэр Есүсийг Израйльд амьдарч байхад жижигхэн хүүхэд байжээ. Маарх Петртэй хамт олон газраар аялжээ. Нэг захиандаа Петр түүнийг миний хүү гэж нэрлэсэн байдаг. Сүүлд нь тэр Есүсийн сургаалыг Европт дэлгэрүүлэгч Пуультай хамт аялж байжээ.

Луух

Луух хэдийгээр Есүстэй хамт байгаагүй ч гэсэн Авралын зарын ном бичсэн юм. Тэрээр Грек эмч байсан бөгөөд нэлээн сүүлд Есүст итгэжээ. Тэр Пуультай хамт удаан аялсан юм. Луух бүрэн дүүрэн баримт цуглуулахын тулд олон гэрчтэй очиж уулзжээ. Тэр бас анхны итгэгч нарын


итгэлийн талаар мөн хэрхэн анхны Есүс Христийн сүм байгуулагдсан талаар бичиж үлдээсэн юм. Энэ бүхэн нь Библид Үйл явдал нэртэй ном болж оржээ.


Иоган

Иоган Есүсийг модон загалмайд цовдлогдон нас барж байхад ч Түүнд үнэнч хэвээр үлдсэн юм. Авралын зарынхаа төгсгөлд тэрээр “Есүс маш их зүйл хийсэн юм. Би энэ бүхнийг Есүс бол Аврагч гэдэгт итгээсэй гэсний үндсэн дээр бичлээ. Тэгснээр та нар Түүний нэрээр шинэ амьдрал олох болно” гэж бичжээ. Есүсийн дагалдагч нараас хамгийн урт насалсан нь Иоган юм. Амьдралынхаа сүүлчийн мөчид тэр дэлхий ертөнцийн төгсгөл, Есүс дахин ирэх тухай Үзэгдэл номондоо бичиж үлдээжээ.

Танд!

Танд зориулсан Есүсийн түүх одоо ч гэсэн хараахан дуусаагүй л байна. Зуун зууныг дамжин энэ түүх хүний амьдралд үргэлжилсээр л. Бас таны амьдралд ч гэсэн үргэлжилж болох юм. Есүс танд өөрийнхөө ивээл хайрыг үзүүлэхийг хүсдэг, бас өөрийн эцэг Ертөнцийн Эзэнийг мэдүүлэхийг хүсдэг. Тэр анх ямар байсан тэр хэвээрээ одоо ч гэсэн байгаа. Тэр бидэнд Ариун Сүнсээ илгээж, бидний амьдралыг үндсээр нь өөрчилнө. Та харанхуйгаас гэрэл гэгээтэй амьдралд шилжиж болно. Есүсийн ачаар Ертөнцийн Эзэний хүсэл таны амьдралд биелэх болно.





Аврагч Эзэн Есүс ном нь Есүс Христийн амьдралын тухай зурагт түүх үү? Тийм. Яагаад гэвэл шинэ үеийнхэн маань өөрийн гэсэн хэлтэй. Зурган өгүүллэгийг газар газрын залуу үеийнхэн ойлгодог. Тийм учраас авралын зарыг шинэ үеийнхэнд хүргэхийн тулд Христийн амьдралыг зурагт өгүүллэгт шилжүүлсэн билээ. Энэ ном бол өвөрмөц ном. Шинэ гэрээний эхний дөрвөн өгүүллэгийг нэг түүх болгон багтаасан бөгөөд уран зохиолын хэлбэртэй боловч Христийн гайхамшигт түүхийг агуулснаараа онцлогтой юм. Бүх хэллэг нь орчин үеийн хэллэг дээр бичигдсэн авч Библиээс огтхон ч гажаагүй юм. Мөн өмнө нь Есүсийн тухай сонсоогүй хүмүүст зориулагдсан Гайхамшигт мэдээ гэж хэлж болно. Энэ ном анх Англи, Дани, Албани хэл дээр хэвлэгдсэн ба Франц, Испани, Португали, Орос, Турк, Араб хэл дээр хэвлэгдэх бэлтгэл хангагдаад байна. “Энэхүү түүх нь Их Эзэний сургасны дагуу

Их Эзэн Христийг дагах хүслийг улам оргилуулж байна.” гэж Левны Бейрут хот дахь Дундад Азийн Библийн нийгэмлэгийн хариуцлагатай нарийн бичгийн дарга Люсиен Аккад хэлжээ.

